

## **Бүгд Найрамдах Энэтхэг Улсаас зохион байгуулагдсан “Цаг агаар, уур амьсгалын судалгаанд сансрын технологийг ашиглах нь” сэдэвт 3 дахь богино хэмжээний цахим сургалтанд хамрагдсан товч тайлан:**

Улаанбаатар

2024.12.18

Нислэгийн Цаг Уурын төвийн, мэдээлэл үйлчилгээний хэлтсийн, урьдчилсан мэдээлэхийн ерөнхий технологич инженер Д.Цэрэннамжил нь 2024 оны 11-р сарын 04-нөөс 11-р сарын 14-ний өдрүүдэд БНЭУ-аас зохион байгуулсан **“Цаг агаар, уур амьсгалын судалгаанд сансрын технологийг ашиглах нь”** сэдэвт богино хэмжээний цахим сургалтанд хамрагдсан.

Энэхүү олон улсын сургалтын зорилго нь Энэтхэгийн цаг уур, далай судлалын хиймэл дагуулуудыг ашиглан Тропикийн цаг агаарын үзэгдлийг урьдчилан мэдээлэхэд гарч байгаа сүүлийн үеийн ололт дэвшилтийн талаар мэдлэг олгох явдал юм.

Нийт 9 өдрийн турш онол, дадлага бүхий дараах агуулга сэдвүүдийн хүрээнд явагдсан. Үүнд:

- Цаг агаар, уур амьсгалын тухай үндсэн ойлголт, агаар мандлын хөдөлгөөн, агаар мандлын тогтворгүйшил
- Тропикийн цаг агаарын системийн тухай ойлголт /циклон, улирлын салхи,../
- Цаг агаарын урьдчилсан мэдээлэх шинжилгээний үндэс
- Сансарын технологит суурилсан цаг агаар, цаг уурын ажиглалт,
- Агаар мандлын хими ба уур амьсгалын харилцан үйлчлэл
- Дэлхийн мөсөн бүрхүүл болон уур амьсгалын өөрчлөлт
- Уур амьсгалын өөрчлөлт, уур амьсгалын төлөвийн загварчлал
- Хиймэл дагуулын мэдээ ашиглан Циклоны замнал ба эрчимжилтийг тодорхойлох, урьдчилан мэдээлэх
- Хиймэл дагуулын мэдээ ашиглан Хэт богино хугацааны урьдчилсан мэдээ гаргах
- Агаар-Далайн харилцан үйлчлэл
- Дэлхийн дулаарал, ба Далайн түвшний өсөлт

Дээрх сэдвүүдийн хүрээнд онол болон дадлагын хичээлүүдийг тухай бүрт нь хослуулан явуулсан бөгөөд БНЭУ-ын хиймэл дагуулын дата ашиглан python болон бусад програмууд дээр цаг агаарын урьдчилан мэдээ гаргах нь уг сургалтын онцлог байсан.

### **Дүгнэлт:**

Энэхүү олон улсын сургалтанд сууснаар онолын мэдлэгээ улам бататгаж, БНЭУ нь хиймэл дагуулын дата ашиглан цаг агаарын урьдчилсан мэдээндээ хэрэглэж буй дэвшилтэт технологитой танилцаж суралцлаа.

Цаашид хийх ажил:

- Хичээлийн хөтөлбөрийн хүрээнд МҮХ-ийн ерөнхий технологич инженерүүдэд сургалт зохион байгуулах

Тайлан бичсэн:

Урьдчилан мэдээлэхийн ерөнхий технологич инженер:

Д.Цэрэннамжил